

Ю.ЦЭДЭНБАЛ, Б.РИНЧЕН, Ц.ДАМДИНСҮРЭН НАР: СӨРГӨЛДӨГЧИД ҮҮ, ХАМТРАН ЗҮТГЭГЧИД ҮҮ?

Ц.Жамбалсүрэн

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: XX зууны Монголын толгойлох сэхээтнүүд болох Ю.Цэдэнбал, Б.Ринчин, Ц.Дамдинсүрэн нарын хоорондын харилцааны талаар олон янзын таамаглал байдаг билээ. Нам, төрөөс үндэстний сэхээтний талаар явуулж байсан бодлогыг тодруулах, түүхийн бодит үнэнийг сэргээх зорилгод тус болох олон баримтыг судлаач гаргажээ.

Түлхүүр үг: Үндэсний сэхээтэн, нам, төрийн бодлого, Ю.Цэдэнбал, Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, "Сэхээтний төөрөгдөл", Үндэсний соёл боловсрол.

Гучаад болон 1950-иад оны дунд үед хавчигдан хохирч явсан үндэсний сэхээтний том төлөөлөгч бол Б.Ринчен гуай байлаа. Зууны гарамгай эрдэмтэн Б.Ринчен нь манай хохирон хэлмэгдэж явсан бодит хүн юм. Тэрээр анх хувьсгалын эсэргүү панмонголизмын тагнуулын байгууллагад оролцож, тагнуулын ба хорлон сүйтгэх ажиллагаа явуулж байсан гэдэг үндэсгүй шалтгаанаар 1937 онд баригдаж, 1939 оны IV сарын 4-ний Дотоод явдлын яамны дэргэдэх комиссын шийдвэрээр буудан алах ял шийтгэгдэж байснаа өөрчилж, 10 жил хорихоор шийтгэгдсэн байжээ. 1941 оны XI дүгээр сард Б.Ринченг Маршал Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нарын аман заавраар хорих ялыг нь өөрчлөн¹, эрдэм соёл, ном бичин хэвлүүлэх үйлсэд түүний авьяас чадварыг ашиглаж эхэлжээ. Ийнхүү Ринчен, Цэдэнбал хоёрын харилцаа аятайхан эхэлжээ.

МАХН-д хоёр удаа элсэж, "баруунтан", хувьсгалын эсэргүү, японы тагнуул гэгдэн мөн хоёр удаа намаас хөөгдөж 1937 онд баригдаж, цаазлагдах ял оноогдож байгаад Чойбалсан, Цэдэнбал нарын зөвшөөрөл, авралаар суллагдсан эрдэмтэн зохиолч Б.Ринчен нам, засгийн удирдагч нартаа баярлан талархаж, МАХН-д элсэх өргөдлөө 1945 оны IV сард Ю.Цэдэнбалын нэр дээр гаргаж байжээ. Түүнд: "Миний тун хайртай ард түмэн, улс олныг минь саруул сайхан ирээдүйн зүг зоригтой чадамгайгаар удирдаж яваа намынхаа эрхэм ариун үйлсэд, ард түмнийхээ тусын тулд би байдаг хүчээ шавхан өгч зүтгэж байна гэж санахад хүн болж төрсний минь хэрэг бүтэв гэж сэтгэл минь тэнэгэр урамтай байна. Миний эх орны учраа мэдэх тэргүүний бүх шилдэг хүмүүсийн зорьж байгаа чин зориг, хүсэж байгаа сайхан хүсэлтэй өчүүхэн миний хүсэл зориг нэг байна. Үнэнхүү сэтгэлийн туйлын эрхэм хүслийг илэрхийлж, Монгол Ардын Хувьсгалт Намд элсэхийг хүснэ. Намынхаа эрхэм үйлсэд, хайрт эх орныхоо төлөө байдаг хүч чадал, сурлага мэдлэгээ шавхаж өгөөд хэрэгтэй бол халуун амиа ч өгөө гэж нэгэн үзүүрт чин үнэнхүү сэтгэлээр зориглосон миний бие ямарч хүнд бэрхээс няцаж зориг шантрахгүйг батлан ийнхүү өөрийн туйлын хүслийг танд үнэн голоос илэрхийлэв"² гэжээ. Дайны хүнд үеийг туулж буй үед, улс орныхоо соёл, боловсролыг хөгжүүлэх эрхэм зорилттой тулгараад байсан энэ үед Монгол дахь боловсрол мэдлэгийн нэг оргил, билгүүн эрдэмтэн Б.Ринчен ийм хүсэлт тавьсан нь намын ерөнхий нарийн бичгийн даргын хувьд том дэмжлэг болж, улс төр, эрдэм ухааны тухайн цагийн "одуудын" нэг нэгэндээ бодитой хандах олон жилийн жирийн харилцаа

¹ Л.Бат-Очир. Чойбалсан: Намтрын нь балархайг арилгахуй- УБ., 1996.т.133-134

² Мөн тэнд

бэхжих нэг үндэс болсон юм. Ю.Цэдэнбал их эрдэмтэнд насан өөд болтол нь жирийн хүндэтгэлтэй хандаж байжээ³.

Б.Ринчен өөрт тохиолдсон аливаа асуудлыг Ю.Цэдэнбалд хэлдэг, зөвлөдөг, тусыг нь авдаг, бас зарим боловсон хүчний өөдгүй ажиллагааны талаар ойлгуулж бичдэг байжээ. 1950-иад оны дунд үеэр намын зарим удирдагч түүнийг мөн л хавчин хохируулж байлаа. Ю.Цэдэнбалд итгэн найдаж бичсэн нэг захидалдаа их эрдэмтэн Б.Ринчен өөрийг нь элдвээр хавчин хяхаж, гүтгэн доромжилж байсан гол хүн бол Намтайширийн Лхамсүрэн байсан гэдгийг хангалттай нотлон үзүүлжээ. Тэрээр бичихдээ: "Д.Сэнгээ аймгуудаас олон захидал авч, уншигчтай хийсэн уулзалт дээр өөрийн нь нэрээ тавьж гаргасан Лхамсүрэнгийн гүжир зүйлийг буруушааж байгаатай тулгарахдаа нэрээ л тавьж гаргаснаас бус, санаа нь сонинд бичих даалгавар өгсөн хүнийх гэдгийг арга буюу хүлээн зөвшөөрсөн юм. Миний тэмдэглэлийн дэвтэрт "Сэнгээ дайрал зохиол бичсэнийхээ төлөө надаас уучлал эрлээ. Аргагүйн эрхэнд бичсэн гэж ам шүд алдлаа. НТХ-ны Нарийн бичгийн дарга Намтайширийн Лхамсүрэнгийн даалгаврыг биелүүлснээ улайлаа" гэсэн 1954 оны IX сарын 24-ний тэмдэглэл бий" гэжээ. Б.Ринчен итгэж хүндэтгэдэг хүний хувьд, улс орны дээд удирдагчийн хувьд Ю.Цэдэнбалд удирдах зарим хүний үнэн нүүр царайг ийнхүү илчилж, Н.Лхамсүрэн нь эрдэм номоор нимгэн, улс төрийн хувьд ч будлиантай хүн болохыг тодорхойлж нэлээн дэлгэрэнгүй захидал бичжээ⁴. Ю.Цэдэнбал Н.Лхамсүрэнг удалгүй 1957 онд НТХ-ны үзэл суртал эрхэлсэн нарийн бичгийн даргын ажлаас чөлөөлж байжээ. Б.Ринченгийн талаар өөдгүй гэж хэлж болох бодлого явуулж байсан Н.Лхамсүрэнгийн талаар Б.Ринчен, Ю.Цэдэнбал нар бараг л адил гэмээр бодлого барьж байсан нь сонирхолтой юм.

Их эрдэмтэн Б.Ринченг үндсэрхэг үзэлтэй, Монгол, Зөвлөлтийн найрамдлын эсрэг "ихээхэн дотуур тамиртай" бодлого баримталдаг гэж албаны Москва үзэж байсан нь монголын удирдагчдыг зарим талаар болгоомжлолд оруулах нэг шалтгаан болж байв. ЗХУ-ын ГЯЯ-наас Элчин сайд В.М.Молотовт 1958 оны III сарын 15-нд ирүүлсэн нууц захидалд "Ринчен шиг хэн ч монголын ард түмний соёлын хөгжилд зөвлөлтийн соёлын үзүүлсэн таатай нөлөөг үгүйсгэж байгаагүй юм. Ринчений явуулгын жинхэнэ мөн чанар, зорилгыг илчлэх талаар ямар нэг арга хэмжээ авч байна уу, үгүй юу гэдгийг нэгд нэгэнгүй ажиглаж байгууштай байна" гэжээ. Зөвлөлтийн элчин сайд Москвад явуулсан хариундаа: БНМАУ-ын удирдах зарим зүтгэлтэн, зохиолчидтой ярилцаж үзэхэд монгол нөхөд ойрын үед өнөөгийн бичигт ямар нэг өөрчлөлт хийх бодолгүй байгаа юм байна. Гэвч хуучин монгол бичгээр байгаа ном хэвлэлийг ашиглах боломжийг бий болгох зорилгоор МАХН-ын ТХ-ны заалтын үндсэн дээр Гэгээрлийн яамны коллег 1958-1959 оны хичээлийн жилийн эхнээс дунд сургуулийн 8, 9-р ангиудад хуучин монгол бичиг заах тогтоол баталжээ. Ринчений үйл ажиллагааны үндсэрхэх чиглэлийн тухайд гэвэл Элчин сайдын яамны зүгээс Ринчений санаа бодлын харгис шинж чанартайг удирдах зүтгэлтнүүдтэй нь ярилцахдаа анхааруулсаар байсан боловч БНМАУ-ын удирдлага уг асуудлыг төдий л анхаарахгүй явж ирсэн. Гэвч сүүлийн үед түүний үйл ажиллагааны хортой талыг хязгаарлах зарим арга хэмжээ авсан юм"⁵ гэж мэдээлж байснаас үзэхэд Б.Ринчений үйл ажиллагааны зарим талд Москва дургүй байсан, энэ чиглэлээр монголчуудад нөлөөлөх гэж оролдож байсан, монголын удирдагчид Ринченг буруутгах талаар яарахгүй байсан, сүүлдээ энэ талаар зарим нэг алхам хийх болсныг ойлгож болох юм. Улс төр гэдэг нарийн

³ Ц.Жамбалсүрэн. Хүмүүнлэг энэрэнгүй ёс, хүний эрхийг хүндэтгэе. УБ., 2003, т. 32

⁴ Мөн тэнд

⁵ Ю.Цэдэнбалын Академийн архив.ф.1,хн.13,т.321

эгзэгтэй билээ. Москва “нэг нүдээр хялайн харж”, өөг нь эрж байсан нэг эрдэмтнийг Ю.Цэдэнбал таалан өргөмжилж, Соёлын сайд ч юм уу, Зохиолчдын хорооны даргаар томилохоос жишээ нь болгоомжилж, Монголын гол хандивлагч орон ЗХУ-ын удирдагчдын санаа бодолд “юм хийхгүй” байхыг бодож байсан бол буруу ч биш байлаа.

Зууны гарамгай эрдэмтэн Б.Ринчен нь хөдөлмөр бүтээлээрээ мандан бадарч, бас хохирч хавчигдаж 1941 онд Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нарын чармайлтаар шоронгоос суллагдсан болохоор Ю.Цэдэнбалд энгийн ханддаг байв. Тэдэнд нэгнийгээ өширхөх ч юм уу, муутан байх хувийн шалтгаан байгаагүй юм. 1960-аад оны сүүлээр Б.Ринчен гуай Москвад зөвлөлтийн эрдэмтэдтэй ном хаялцаж заримд нь хатуу үг хэлсэн тухай мэдээлэл манай албаны хүмүүст ирж, соёлын салбар хариуцдагийн хувьд Д.Төмөр-Очир гуай материал бүрдүүлж, УТТ-ны хурлаар оруулах болжээ. Хуралдааны танхимд их эрдэмтэн тухтай нь аргагүй сууж, бас тамхи татаж эхэлжээ. Ерөнхий даргаа хүлээж байсан II дарга нар их л дургүйцэн түүнийг харж, хурал ч халуухан болох янзтай болжээ. Энэ үед Ю.Цэдэнбал орж ирэн, ямар асуудал яригдахыг лавлах зуураа их эрдэмтнийг “Та наашаа суу” хэмээн ойртуулан суулгаж, бүр тамхи, үнсний сав дөхүүлж өгчээ. Ингэсний нөлөөгөөр яриа хөөрөө ч аятайхан болж гадаадын хүмүүстэй соёлтой ярилцахыг хуралдагсад түүнд зөвлөж, харин Ю.Цэдэнбал жолоочдоо Ринчен гуайг хүргэж, гэрт нь оруулж өгөөрэй гээд явуулжээ. Донгодуулахаар ирсэн их эрдэмтэн маань тамхиар дайлуулаад, эрхэм сайдуудтай зэрэгцэн сууж хуралдаад, машинаар хүргүүлж буцаж байсныг тэр сонин хуралд оролцсон, доктор, профессор Д.Содномгомбо дурсан ярьж байлаа⁶.

1968 онд Б.Ринчен Ю.Цэдэнбалд захидал бичиж номыг нь цензурдэн хэвлэж өгөхгүй байгаа тухай мэдээлж, хэвлэж өгөхийг хүсэхийн хамт: “Миний бичсэн “Монгол бичгийн хэл зүй, хэлбэр судлал” хэмээх хөөрхий заяа муутай гутгаар дэвтрийн талаар Танд дахин дуулгах хэрэг гарлаа. Уг ном гурав дахь жилдээ хэвлэх үйлдвэрт хэвтэж байна. Энэ хугацаанд анхандаа номыг маань устгаж, хэвлэсний бүх зардлыг надаар нөхөн төлүүлэх шийдвэр нэг гаргаж үзсэнээ 1967 оны III сарын 29-нд Танд уламжилсны дараа дээрх шийдвэрээ түр азнуулаад, өнгөрөгч оны адгаар Академийн санхүү надаар мөнгө төлүүлэхээ болив гэж надад мэдэгдлээ”⁷ гэж бичсэн нь ном хэвлэхтэй холбогдон орсон хүнд байдлаас Ю.Цэдэнбал түүнийг гаргасанд талархсан хэрэг байлаа.

1976 оны VIII сарын 2-нд Ю.Цэдэнбалд итгэн найдаж бичсэн өөр нэг захидалдаа Б.Ринчен өөрийг нь элдвээр хавчин хяхаж, гүтгэн доромжилж байсан гол хүн бол Намтайширийн Лхамсүрэн байсан тухай бичихдээ: “НТХ-ны суртал ухуулга эрхэлсэн нарийн бичгийн дарга асан, бүтээл зэхий явдлыг нь Монголын олон нийтийн сайн мэдэх Н.Лхамсүрэн анхны шүүмжлэлийг бичүүлэн “Үнэн” сонинд олон нийтийн нэрээр нийтлүүлж, ... гүтгэж муучилсанд олон нийт дургүйцэж байсан юм шүү. Орос буюу Англи бичгийн хэл нь Орос буюу Англи ард түмний бахархал болж байдаг шиг Монгол бичиг зохиолын хэл манай ард түмний баялаг гэдгийг Лхамсүрэн, юмыг түүний нүдээр харагчдад буюу манай ардын ярьдагчлан түүнийг хүн хорхойчлон дууриадаг хүмүүст ойлгуулах гээд ядчихсан билээ. Одоо ч гэсэн ард түмнийхээ бичгийн хэлийг “архаизм” буюу хуучирсан хэл гэж нэрлэсээр байгаа хүмүүс тааралдаж байна. Н.Лхамсүрэн тэгэхэд тиймэрхүү “архаистуудыг” өөгшүүлж, өөрийнх нь айлдвараар талийгаач Сэнгээгийн бичсэн дайрал шүлэгт намайг үндсэрхэх

⁶ Зохиогчийн хувийн архив

⁷ Б.Ринчен. Монголын за андагаар буйзаа. УБ., 2000, т.281

үзэлтэн, монголын феодал ангийн бичиг зохиолын хэлийг магтагч гэж, “Үүрийн туяа” романаа энэ хэлээр бичсэн гэж зэмлэснийг дэмжиж буй. 1947 онд дуусгасан “Үүрийн туяа” романы тэргүүн дэвтрийн гар бичмэлийг Маршал Чойбалсан сонирхон үзэж, ТХ-ны зөвлөх Кондратьев бас уншиж үзнэ гэхэд нь би өөрөө оросоор орчуулж тэрбээр уншсан боловч Лхамсүрэн уг романыг хэвлэхийг 1951 он хүртэл саатуулсан тухай тэмдэглэл дэвтэрт минь байдаг юм. Зөвлөлтийн зохиолчдын хийсэн, англи эхийн шүлгийн хэмжээг хадгалж чадсан сайхан орчуулгаас миний орчуулсан Шекспирийн Отеллогийн орчуулгын бичмэлийг уншсан бүхэн сайн ойлгож байсан боловч уг орчуулгыг Лхамсүрэнгийн үед монголын феодалын хэлээр орчуулсан гээд хэвлээгүй орхисон билээ. А.С.Пушкины “Хириг Рыцарь”-ийг орчуулсныг минь бас л хэвлээгүй. Мянга мянган голч шудрага эх орончын аминд хүрсэн цусан гарт алуурчдын хэрэглэж байсан “үндсэрхэх үзэлтэн” гэсэн пайзыг янз бүрийн Лхамсүрэн нар надад зүүж, ... байгаагаар үзэхэд тэд чухам ямар улс вэ гэдэг нь тод харагдаад өгнө” гэж Ю.Цэдэнбалд учирлан бичжээ. Монголын толгойлох сэхээтнүүдийг хавчих бодлогыг тухайн үед хэн баримтлаад байсныг энэ захидал тодорхой харуулж байна. Харин Н.Лхамсүрэнгийн байр суурь, байдал Ю.Цэдэнбалд бүр тавиад оны үед тодорхой байсан юм. Н.Лхамсүрэн нь тэр зөрөлдөөний үед 1957 онд НТХ-ны Үзэл суртал эрхэлсэн нарийн бичгийн даргын ажлаас чөлөөлөгдөж байлаа. Б.Ринченг ухаантай хүн гэж үздэгийн хувьд түүний удаа дараагийн захиаг Ю.Цэдэнбал зарим хүний матаас гэж үздэггүй байжээ. Ю.Цэдэнбал их эрдэмтнийг хүндэтгэж, үг санааг нь сонсож, туслалцаа зөвлөгөөг нь ч авдаг тохиол байжээ. Түүний туслах байсан Л.Батцэнгэл дурсамжийн номондоо бичихдээ: “1969 оны IV сарын 10. Энэ өглөө ажилдаа ирээд удаагүй байтал Дарга ирж өрөө рүүгээ орох зуур намайг дуудав. Араас нь дагаж ороход Дарга жижиг тэмдэглэлийн цаасан дээр “хадаг, цай, мөнгө” гэсэн үгийг бичиж юу билэгддэг болохыг товчхон бичих үүрэг өглөө. 1969 оны IV сарын 11. Дарга надаас: “Чи Ринчен Бямбаевын гэрийг мэдэх үү гэж асуухад нь мэдэхгүй, энэ хойноос явж байгаа харагддаг юм. Энэ хавьд ойрхон байдаг байх” гэвэл Дарга: “VII дэлгүүрийн хойно байдаг юм. Чи энэ тайлбараа авч очиж, орчуулуулаад ир. Би утсаар хэлсэн байгаа гэв. Даргын зааснаар намайг очиход их зохиолч үүдээ нээн “Та орогтун” хэмээн урив. Мэнд усаа мэдэлцсэний дараа миний бие хэрэг зоригоо хэлтэл, Ринчен: Т⁸ом Дарга мөхөс намайг тоож хандсанд баяртай байна гээд... өөр өрөөнд авч очсон тайлбарыг орчуулж, надад буцааж өгөхдөө “Даргадаа намайг хичээнгүйлсэн болохыг айлдана биз” гэснээр энэ их хүнтэй хэдэн үг сольсноо олзуурхаж явдаг юм. Цэ дарга ийнхүү билгүүн номч Ринчен гуай, түүний эрдмийг дээдэлж явсан”⁹ гэж тэмдэглэн бичжээ. Ю.Цэдэнбал “Намын амьдрал”-д Б.Ринченгийн талаар “цагаантны үлдэгдэл” гэж бичсэнд дургүйцэн сэтгүүлийн эрхлэгч рүү нь утасдан замчандаж, их эрдэмтэн бие чилээрхүү байхад Москвагийн эрдэмтэн докторт утасдаж сайн эмчилж өгөхийг хүсч байсанд Ринчен гуай баярласнаа ярьдаг байсныг ахмадууд дурссан байдаг¹⁰ билээ.

Нам, төрийн тэргүүн маань эрдэмтний гэр бүлийнхнийг ч хүндэтгэн үздэг байж. Б.Ринчений хүргэчүүл нь Ю.Цэдэнбалын ойр дотны хамтран зүтгэгчид байв. Н. Туваан Эрүүлийг хамгаалах яамыг олон жил толгойлж, Монголын анхны доктор Н.Жагварал Ю.Цэдэнбалын хамгийн ойрын шадар тушаалд олон арван жил гар нийлэн ажиллаж байжээ. Ринчений хүү, гялалзсан эрдэмтэн Барсболдыг Цэдэнбалынхан өндөр үнэлдэг байсан бөгөөд А.И.Цэдэнбал-

⁸ Б.Ринчен. Монголын за андагаар буйзаа. УБ., 2000, т. 319-325

⁹ Л. Батцэнгэл. Миний мэдэх Ю. Цэдэнбал. УБ., 2002, т. 255-256

¹⁰ Ю.Цэдэнбал: Хүмүүсийн дурсамж. б.1.УБ., 2002.т.143

Филатова өөрийн нэгэн дурсамжид: "Монголын нэрт эрдэмтэн Бямбын Ринчений хүү Барсболдын эзэмшсэн мэргэжилдээ дур сонирхолтой, түүнийгээ бүрэн дүүрэн мэддэг чанар нь миний итгэл бишрэлийг төрүүлсэн юм. Балар эртний үлэг гүрвэлийн тухай түүний яриа миний сонирхлыг туйлын их татаж, тэрхүү сөнөж мөхсөн амьтны эх орон бол монгол орон, монголын элсэн говь байсан тухай ярихыг сонссоор хоёр, гурван цаг өнгөрснийг анзаараагүй юм... Нэрт эрдэмтний хүү гэсэндээ маш их боловсролтой болсон тэр Барсболд гэдэг залуу эрдэмтний яриа үнэхээр сонирхолтой байсан тул хамгийн жижгээс авахуулаад хамгийн том үлэг гүрвэлүүдийг харуулсан баримлуудыг бариулахаар захиалга өгсөн... Гэвч эхлүүлсэн ажлаа гүйцээж чадалгүй Москва руу би явсан"¹¹ гэжээ. Хүүхдийн парсад үлэг гүрвэлийн цэцэрлэгт хүрээлэн байгуулах гэж тэр төлөвлөж байжээ. Энэ бүгдээс үзэхэд Монголын үндэсний толгойлох сэхээтнүүд болох Ю.Цэдэнбал, Б.Ринчен нар өөр хоорондоо төдийгүй гэр бүлийнхний нь хувьд ч нэгийгээ хүндэтгэсэн жирийн сайхан харилцаатай байжээ гэдэг дүгнэлт гарч байна. Үнэн амьдрал дахь хүмүүсийн сайхан харилцаанд улс төр үргэлж ч дарамтлалд байсангүй. Улс төр, эгэл амьдрал хоёрыг тэр үед бүх зүйлд ч хутгачихдаггүй байжээ.

Бас тодорхой зарим асуудлаар үзэл бодол нийлэхгүй зүйл ч байсан байж болох бөгөөд Монгол хэл шинжлэлийн нэрт эрдэмтэн Чой.Лувсанжав Ринчен гуайн талаар ярьсан ярилцлагадаа Монголын шинжлэх ухаанд хүндтэй гавьяа байгуулсныг нь үнэлснээс гадна Б.Ринчен гуайн ярьж хэлж байсан зүйлээс дурсаж бичжээ. Тэрээр: Ри багштан Сталиныг "хүн алахдаа бол Гитлерийн багш нь" гэж айлддаг байсан. "Сталин, Чойбалсан, Цэдэнбал нар интернационализм, социализм, найрамдал зэрэг хуурамч үгээр, тийм ийм хүмүүжил гэдгээр монгол түмний тархийг гашилгаж орхисон юм. "Цэдэнбалын хэлж байгаа үг чинь юуны Цэдэнбалын байх вэ? Цэдэнбалын ар шил рүү нь Кремлиэс бүрээдэж байгаа цуурай", Цэдэнбалыг тойрсон тушаалтнуудыг хулчгар бялдууч нар, үхэр монголчууд гэдэгсэн. "Монгол хүн монголынхоо сайчуул мэргэдээ юу боллоо гэж алан хядах вэ, жорлонгоос бусад бүх албан газарт Сталинчин зөвлөх сургагч ирж буу тулган хийлгээд, одоо болохоор монголчууд мунхагтаа чингэсэн мэт гөрдөж байна". "Ер нь нэр томъёогоо л сайн орчуулахгүй бол манай хэлний тэн хагас нь орос боллоо" гэж айлдахад би: бүх нэр томъёог орчуулах уу? гэхэд багштан: "тэгэлгүй яах вэ, хулигаан, оочер хоёроос бусдыг хуу орчуулсан нь дээр. Тэр хоёрыг орчуулахгүй байхад хаанаас ирсэн нь мэдэгдэж байг", "Би чамд том дарга болох сайн арга зааж өгье. Чи километрийн газраас үнэртэхүйц шар эгч нэгийг олоод тэвэрчих, тэгээд л чамд орлогч сайд, оготор ногоон машин, орон сууц гурав дорхиноо бэлэн болно доо гэхэд бид машин дүүрэн инээд болж билээ"¹² гэж бичжээ. Үнэхээр Ринчен багш тийм ухаантай хүн мөртлөө тухайн цаг үедээ дэндүү гэмээр хурц үг ярьж байсан уу?, аль эсвэл ерэн оны үйл явдлаар хувьсгалжсан эрдэмтний, аль эсвэл сонин хэвлэлийн ажилтны бодол санаа туссан уу гэдгийг түүх амьдрал тодруулах цаг удахгүй ирэх бизээ.

Иймэрхүү үзэл бодолтой том сэхээтнүүд нэг биш байсан гэж бодоход Ю.Цэдэнбал тийм хүмүүстэй учир зүйгээ яаж ийгээд олж, гол нь Монголын ард түмэн, ялангуяа залуу үеийн зүрх сэтгэлд найрамдал, нөхөрлөл, эв санааны нэгдлийн үзэл санааг төлөвшүүлэх үйлсэд амин чухал ач холбогдол өгч, энэ зорилгынхоо төлөө насан турш хичээнгүйлэн зүтгэжээ.

¹¹ Есөн туг. (Ю.Цэдэнбалын Академийн сонин). 2002, № 3, 4, т. 14

¹² Утга зохиол, 1990. XI.30, № 49

Ю.Цэдэнбал, Б.Ринчен нарын үед Монголчуудын оюуны амьдрал гэгээнжиж, эх орондоо төдийгүй дэлхийд данстай их эрдэмтэд зохиогчид төрөн гарсан юм. Монголын шинэ утга зохиолыг үндэслэгчдийн нэг Ц.Дамдинсүрэн, зохиолч, найрагч Д.Цэвэгмид, Э.Оюун, Д.Намдаг, Ц.Гайтав, Б.Явуухулан, Ч.Ойдов, С.Эрдэнэ, Л.Ванган, Ч.Лодойдамба, Ч.Чимэд, С.Удвал, Л.Түдэв нарын их зохиолчидард түмнийхээ зүрх сэтгэлд үүрд үлджээ. Нэрт хэл шинжлэгч Ц.Дамдинсүрэн, Ш.Лувсанвандан, Ш.Гаадамба, Д.Чойжилсүрэн, Д.Цэрэнсодном нарын мөнхийн бүтээлүүд чухам энэ үед л бүтээгджээ. Энэ гавъяат хүмүүсийн дунд Б.Ринчен өөрийн тодорхой байр суурьтай байсныг улс төр хэмээх салбарт Ю.Цэдэнбал ямар байр суурьтай болохыг манай ард түмэн сайн мэднэ. Сайн хүмүүсийн дунд муу хүмүүс л “үг зөөдөг” билээ.

Тавиад оны “төөрөлдсөн сэхээтний” гол төлөөлөгч, хэд хэдэн удаа элдэв хэл ярианд орж хэлмэгдэж явсан үндэсний томоохон сэхээтэн Ц.Дамдинсүрэн нь амьдралын сүүлчийн жилүүд хүртлээ Ю.Цэдэнбалын дотно хүн нь байж, дуртай үедээ утасдаж, уулзаж, хүсэл зориггоо хэлж шийдүүлж байсан ажээ. Нэрт эрдэмтэн Ц.Дамдинсүрэн гуай “сэхээтний төөрөгдлийн” үеэс л Б.Ширэндэвт дургүй байжээ. Тэрээр “Үндэсний соёлын өвийг хамгаалъя” гэсэн өгүүлэл бичиж Ширэндэвийг сайтар шүүмжилжээ. “Үнэн” сонин хэвлэж өгөхгүй болохоор Бал даргад хэлж, Бал сонинд утасдаж, түүнийг хэвлүүлсэн нь тэр үедээ л тун сенсаци бүхий нийтлэл болж байжээ. Сургуульд хамт сурч байсан найзаасаа илүү дотно сэтгэлээр Ц.Дамдинсүрэнд ханддаг байсан уу, аль эсвэл хүний хэвлэн нийтлэх эрхийг бодсон уу, ямар ч л гэсэн тэр монголыг шуугиулсан өгүүллийг нь Ю.Цэдэнбал нийтлүүлж өгч байжээ¹³.

Энэ өгүүлэл нь монголын тэргүүлэх сэхээтний нэг Ц.Дамдинсүрэн, нам, засгийн удирдагчдын чухам хэнтэй нь илүү мөчөөрхөлдөж байсныг харуулав. Үүнд: “1950 онд хэвлэгдсэн Шинжлэх ухаан сэтгүүлийн 3-рт Дашдэндэв “Нууц товчоо” “Гэсэр”, “Жангар” гурвыг феодал ноёдын харгис зохиол гэж бичсэн ба мөн оны 1 сард Жамбалсүрэн, Тарваа нар “Үнэн” сонинд дурдсан 3 зохиолыг феодал ноёдын харгис зохиол гэж бичсэнийг бид зөвшөөрч чадахгүй. Б.Ширэндэв Их сургуулийн захирал байхдаа тэдэнтэй санал нийлж, Гэсэрийн тууж, Жангарын үлгэр хоёрыг Их сургуулийн программаас хасаж хаясан байна. Гэтэл эдний шоовдорлож байгаа Гэсэрийн тууж, Жангарын үлгэр хоёр бол Монголын жинхэнэ ард түмний үнэн хүсэл эрмэлзлэлийг илэрхийлсэн ... чиглэл бүхий зохиол юм. Ард түмний соёлын чухал өв болсон ийм зохиолуудыг феодалын зохиол, ноёдын бүтээл, харгис ном гэх зэргээр харааж байсан явдал бол үндэсний соёлын өвийг үгүйсгэх үзлийн илрэл болно. ... Ерөнхийдөө Монголын хэвлэлийн ажил сүүлийн хориод жилийн дотор их өргөжиж хөгжсөн байхад соёлын өв болох дурсгалт бичиг хэвлэх явдал бүр зогссон байна. Б.Ширэндэв, Н.Лхамсүрэн нар соёлын талаар хариуцлагатай ажил хийж байх завсар жил бүрийн хэвлэлийн төлөвлөгөөнөөс соёлын дурсгалт бичиг хэвлэх явдлыг баллан хассаар нэг ч дурсгалт бичгийг хэвлүүлсэнгүй гэдгийг шууд хэлбэл зохино. 1955 онд Монгол хэл дээр хэвлэгдсэн Монгол Ард Улсын түүхийн дэвтрийн эцэст алдаа мэдгийг залруулах хуудас хавчуулсан байна. Энэ хуудсан дээр уг түүхийн 237-р хуудсанаас хэдэн мөрийг битгий уншаарай гэж бичжээ. Тэр уншиж болдоггүй мөр нь юу вэ гэвэл, манай Монголын алдартай ерөөлч Гэлэгбалсан, Лувсан хуурч хоёрын тухай өгүүлсэн зүйл байна. Нөхөр Ширэндэв редакцийн бусад гишүүдтэй огт зөвлөсөнгүй, ганцаараа шийдвэрлэж энэ ерөөлч, хуурч хоёрын нэрийг балласан байна. Манай зарим сэхээтэн хүмүүс өнгөрсөн түүхийн баримтаас үнэнийг олж хэлэхийн оронд

¹³ Ю.Цэдэнбалын Академийн архив. ф.1, хн.3, т.360

элдвээр гуйвуулан ташааруулж, урьдын харанхуй бүдүүлэг байсныг улам харанхуй бүдүүлэг болгож, эцэг эх, эмгэд өвгөдөө бүр зэрлэг амьтад байсан мэт хэтэрхий доромжлон бичих явдал үзэгдсээр байна. Жишээ нь: Автономит засгийн үед 49 тооны бага сургууль байжээ. Тэр сургуульд зориулж хорголжин бараар хэвлэсэн усны шаштир, модны шаштир, цаасан шувууны үлгэр зэрэг ном нь одоо байгаа бөгөөд сурч байсан хүмүүс нь амьд байна. Тэгэхэд Б.Ширэндэв “Монгол дахь ардын хувьсгал” гэдэг номондоо ганц сургууль байсан гэж бичсэн ба Аварзэд 1956 оны VII сарын 14-ны “Үнэн” сонинд автономитийн үед ганц ч сургууль байгаагүй гэж бичлээ. ... Монгол, Түвд хэл бичиг мэдэх хүн монголын хүн амын зууны 5% байсан байна. Гэтэл Б.Ширэндэв 1950 онд “Монгол ардын хувьсгалын 30 жилийн ой” гэдэг үгүүлэлдээ 1000 хүний 7 нь бичиг мэддэг байсан гэж бичээд, дараа нь 1955 онд “Монгол дахь ардын хувьсгал” гэдэг номдоо 1000 хүний 5-нь бичиг мэддэг байсан гэж түүхийг гуйвуулж бичлээ. Тэгээд бас бичиг мэдэх хүмүүсийг “Цөм феодал ангийн төлөөлөгчид байсан” гэж “30 жилийн ойн” тухай үгүүлэлдээ Б.Ширэндэв бичлээ. Урьд цагийн соёлын тухай мэдээг гуйвуулан бүр юу ч байгаагүй мэтээр бичиж байгаа явдал бол соёлын өвийг үгүйсгэх үзлийн нэг илрэл мөн тул ингэж ташааруулан гүтгэж бичих явдалтай тэмцэх хэрэгтэй байна”¹⁴ гэж хурцхан шүүмжилжээ. Монголын урьдаа барьдаг сэхээтнүүдийг тэр үед чухам хэн дарамтлан хохироогоод байсныг Ц.Дамдинсүрэн гуай тод томруун бичсэн бөгөөд тэд нь Б.Ширэндэв, Н.Лхамсүрэн нар байсан гэж ойлгогдохоор байна. Ц.Дамдинсүрэнгийн энэ мэт алхамууд нь тэр үеийн намын удирдлагын хэт хуучинсаг хэсгийнхний хариу дайралтын шалтгаан болсон байна.

Монголын нэрт эрдэмтэн Ц.Дамдинсүрэнг бараг л Цэдэнбалын өрсөлдөгч мэтээр ярьж, энэ далимд Цэдэнбалыг муучлах бодолтой хүмүүсийн бодол, сэдэл мухардалд орж байгаа юм. Дөчөөд онд Ю.Цэдэнбал, Ц.Дамдинсүрэн нар тэр үеийн сэхээрэлт хүмүүсийн хувьд нэг нэгнээ дэмжиж, тэр ч байтугай Ц.Дамдинсүрэн орост олон жил болсон Ю.Цэдэнбалд эхнэр олж өгөх гэж хөөцөлдөж, туслах гэж үнэн сэтгэлээс чармайж байсан түүхийн мэдээ үлджээ. “Ю.Цэдэнбал, Ц.Дамдинсүрэнгийн танил бичээч орос бүсгүй Лератай уулзаж эхэлсэн нь овоо бүтэлтэй болохоор байжээ. Дамдинсүрэн дурсан ярьсан нь: Долоо хоногийн дараа Лера над дээр магнай хагартал баярласаар ирлээ. Ю.Цэдэнбал бид хоёр суухаар болсон, хуримаа одоохон хийе гээд байна. Гэсэн ч би долоо хоног хойшлуулъя гэлээ... Хэдэн хоногийн дараа Лера над дээр нус нулимс болсоор ирэв. Цэдэнбал больё гэнэ. Зөвлөлтийн элчингийнхэн л: хэвлэх үйлдвэрийн үсэг өрөгчийн охиноор чи яах гэсэн юм бэ? “Соёл боловсрол гэхээр юмгүй, эгэл гарал үүсэлтэй. Ер нь чамд тохирохгүй” гээд болиулчих шиг боллоо гэж билээ” гэжээ¹⁵. Үнэхээр Ц.Дамдинсүрэн харь газар олон жил болсон, ажлаас өөр юм мэддэггүй сайн нөхөр Цэдэнбалд сайхан сэтгэлийн үүднээс туслая гэж чармайж байсан нь нотлогддог юм.

Үндэсний үзэлтэй Ц.Дамдинсүрэнг интернационалч үзэлтэй Ю.Цэдэнбал ямагт хавчиж байсан тухай үлгэр амь бөхтэй яригддаг боловч намын дарга Ю.Цэдэнбал өөрийн эрх мэдлийн хүрээнд Ц.Дамдинсүрэнг 1943 оны X сарын 7-нд “Матар” сэтгүүлийн эрхлэгчээр томилж¹⁶, 1945 оны VIII сарын 24-нд УИС-ийн багшаар томилж¹⁷, Х.Чойбалсан ЗХУ-д эмчилгээнд байсан үед буюу 1952 оны I сарын 25-нд Шинжлэх ухааны хүрээлэнгийн даргаар томилжээ¹⁸. 1950 онд

¹⁴ МУ-ын Засгийн газрын архив. ф. 1, т. 4, х.н. 20, т. 239-247

¹⁵ Л.Шинкарев. Цэдэнбал, Филатова хоёр: Хайр дурлал, эрх мэдэл, эмгэнэл-УБ., 2004, т. 50

¹⁶ МАХН-ын Төв архив. ф. 4, т. 12, х.н. 23, т. 245

¹⁷ МАХН-ын Төв архив. ф. 4, т. 12, х.н. 21, т. 101

¹⁸ МАХН-ын Төв архив. ф. 4, т. 19, х.н. 20, т. 24

Монгол Улсын төрийн сүлд дуулал зохиох үүргийг чухамхүү Ц. Дамдинсүрэнд итгэн олгож, 1951 оны VII сарын 5-нд УИХ-ын тэргүүлэгч гишүүн болгож¹⁹, 1953 оны IX сарын 30-нд УТТ-ны 76/205 дугаар хурлын тогтоолоор Монголын зохиолчдын хорооны дарга болгож²⁰, 1955 оны III сарын 8-ны УТТ-ны 141 дүгээр хурлын тогтоолоор Ц.Дамдинсүрэнг Хельсинкт болох Дэлхийн энх тайвны талынхны Ассамблейд оролцох төлөөлөгчөөр томилж²¹, Ц.Дамдинсүрэнд итгэл хүлээлгэж, бүх талаар дэмжиж байсан хүн нь үнэн хэрэгтээ Ю.Цэдэнбал мөн байсан тухай олон баримт үлджээ.

Хэрэг дээрээ Ю.Цэдэнбал, Ц.Дамдин нарын харилцаа ямар байсан нь сонин юм. Бидний үзэж буйгаар Ю.Цэдэнбал нарын харилцаа эгэл жирийн, бас олон жил нэг нэгнийгээ хүндэтгэсэн шинжтэй байсан юм. Философич эрдэмтэн Д.Дашжамц хуучилснаар: “Нэг удаа Ю.Цэдэнбалын туслах Ц.Дамдинсүрэнд утасдаж: “Дарга тантай уулзахаар урьж байна. Даргын машин 5 цагт очно” гэжээ. Удахгүй дээд газар түүнийг дуудаж арга хэмжээ авахаар зэхэж байсныг таамагласан академич Төрийн тэргүүнийхээ гэрт зочилон очжээ. Ширээ засчихсан, коньяк, идээ будаа тавьчихсан байлаа. Дарга, эрдэмтэн хоёр нилээн тухтай ярилцаж, бас ч гэж маргалдаж, хөөрөлдсөөр олон цаг болжээ. Энэ зуур Ю.Цэдэнбал “Том хурал болж чиний асуудлыг хэлэлцэх нь ээ. Чи ерөнхийдөө дутагдлаа хүлээх байдалтай л байх нь дээр” гэж зөвлөж байжээ. Хожим “Толийн хавсралтын тухай” УТТ-ны тогтоолыг хэл, түүхийнхэн хүлээж авах хурал болж, хурлын явцын бичлэгийг НТХ-ны тухайн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга гадаадаас ирээд байсан Ю.Цэдэнбалд танилцуулахад хэдэн минут чагнаад магнитофоныг нь зогсоож “Дамаа том эрдэмтэн, бидний ажилд тун их тус болсон доо. Цаашид ч их тус болно. Бид л түүнтэй сайн, ажиллаж чадахгүй байна даа” гэж хэлжээ. Дамаа академич: “Цэ бид хоёр чинь эртний найзууд шүү дээ. Би их түргэн амтайгаасаа л болдог. Харин би түүний үгэнд оролгүй гомдоож байсан тал бий” гэж ярьж билээ” гэжээ. Нэрт эрдэмтэн, академич Ц.Дамдинсүрэн өөрийн нугачаа, давалгаатай ер бусын амьдралын тухай хожим дурсахдаа: “Дээд газраас намайг зэмлэж байсан удаа олон, алдааг засаж, зөвийг заасан ч олон. Ийнхүү буруушаахын хамт урамшуулан сайшааж төрийн дээд шагнал хүртээсэн удаа бас олон. Одон медаль, алдар цол, Төрийн 3 удаагийн шагнал ч бий. Эх орон, ард түмэн, нам, засагтаа үнэнч явж ирсэн бөгөөд цаашид ч үнэнч үр бүтээлтэй ажиллахыг чармайна”²² гэжээ.

Тавиад оны “төөрөлдсөн сэхээтний” гол төлөөлөгч, томоохон эрдэмтэн Ц.Дамдинсүрэн Орос-Монгол толины хавсралтын хэл амнаас болж УТТ-гоор ширүүхэн орж хэлэлцэгдэж байсан тэр хүнд үед Ю. Цэдэнбалын байр байдал, хандлага тун сонин “ойлгомжгүй” байжээ. Мэдээжээр олон түмний мэдээлэл, нөгөө талын саналыг харгалзан үзэж, тодорхой зарим асуудлаар зарчмын гэмээр байр бодлого барьсан ч, нэлээн ширүүн маягтай эхэлсэн хурлыг зөөлрүүлж, ухаантай тайван хандах үлгэр үзүүлж, академич Ц.Дамдинсүрэнгийн талаар дараах зүйлийг онцлон тэмдэглэжээ. Үүнд: “Би нөхөр Дамдинсүрэнг гучаад жил мэднэ. Дайны хэцүү үед хамт ажиллаж байсан. Ц.Дамдинсүрэн намын бодлогыг биелүүлэхээр шаргуу зүтгэж байсан. Түүнээс хойш зохиолч, эрдэм шинжилгээ, олон нийтийн ажил хийж ирсэн. Амьдралын ихээхэн туршлагатай хүн. Сүүлийн нэлээд хэдэн жил Орос, Монгол толь бүтээхээр ажилласан. Н. Лувсандэндэвтэй хамтран ажилласан. Энэ хоёр толийн хувьд ч ихээхэн тустай ажил хийсэн байна. Хэрэв үүнд дүгнэлт өгөхгүй

¹⁹ МАХН-ын Төв архив. ф. 18, х.н. 3, т. 63

²⁰ МАХН-ын Төв архив. ф. 18, х.н. 21, т. 22

²¹ МАХН-ын Төв Архив. Ф.22, х.н.25, т.102

²² Д.Дашдорж. Да багшийн дурсамж яриа – УБ., 1988. т.89

бол нам, ард түмний өмнө гэмт хэрэг хийсэнтэй адил юм. Нам, ард түмэнтэйгээ хамт олон жил ажилласан, манай соёлыг хөгжүүлэхэд их хувь нэмэр оруулсан, мөн өөрийн амжилтыг гадаадад сурталчлахад их зүйл хийсэн манай урдаа барьдаг хүн... урдаа барьдаг хүнээ бүдрэхээс нь зайлуулах хэрэгтэй юм. Энэ дутагдал бол нийгмийн үзэгдэл юм”²³ гэж хэлжээ. Хурлын уур амьсгал ч зөөлөрч, бас ч гэж зоригжсон академич маань: “Би хийсэн юмаа зөв гэж үзсэн. Одоо хэлээд байх зүйл алга” гэж хэлснээ “би бодъё” гэж нэмж хэлжээ. Академич Дамдинсүрэнд угаасаа сайнаар ханддаг Ерөнхий нарийн бичгийн дарга: “Тиймээ. Сайн бодох хэрэгтэй” гэж тайвнаар хэлж байжээ.

Нэрт хэл судлаач, доктор, профессор С.Галсан өдрийн тэмдэглэлдээ бичихдээ: “Би Сонгины амралтад амарч байв. Энэ өдөр Да багш (академич Ц.Дамдинсүрэн) надтай ирж уулзав. Багшийн нүүрэнд баярын мишээл тодрон баярлаж хэлэх нь: “Муу өвгөн багшийг чинь төрийн тэргүүн Ю.Цэдэнбал өчигдөр хүлээн авч тоож уулзсанд баярлаж чамд хэлэхээр ирлээ... Дарга надаас “за ямар санал хүсэлт байна?” гэхэд нөгөө хэвлэлд бэлтгэсэн монгол герман 2 хэлний толь бичгийг хэвлүүлж чадахгүй явна гэдгээ хэлэхэд дарга надад зардал олгоно гэв. Би монголд эртний төвд судлалыг хөгжүүлэх шаардлагатай байна. Манай хүрээлэнд төвд судлалаар 6 орон тоо нэмж олгохыг хүссэнээр 6 орон тоо нэмж өглөө. Харин түүний 3-ыг Нацагдоржид (ШУА-ийн дэд Ерөнхийлөгч байсан.) булаалгачихлаа. Түүнийг мэдсэн бол 10 орон тоо хүсдэг байжээ. Төрийн тэргүүн хүн эрдэм шинжилгээний ажлын хүнд бэрхийг ингэж үүрэлцэж, бидний санал бодлыг сонсож туслаж дэмждэг нь сайхан хэрэг хэмээн Цэдэнбалын ухааныг гайхаж явлаа”²⁴ гэжээ.

Ю.Цэдэнбал Монголын тэргүүлэх сэхээтнүүдийн гол төлөөлөгч Ц.Дамдинсүрэнг хатуурхан хэлмэгдүүлж байсан, энэ мэтээр ер нь л сэхээтнүүдийнхээ эсрэг ажиллаж байсан маягын зэмлэл судалгаагаар нотлогдохгүй байна. Энэ нь хоёр хүний харилцааг зориуд харлуулан гуйвуулсан хэрэг бөгөөд баримт нотолгоо нь түүхэн үнэн өөр байсныг харуулж байна. Эрдэм боловсролтой энэ хоёр хүний сайн сайхан харилцааны тухай олон жишээ гарч ирсээр байна.

Abstract: Political and party leader Uy. Tsedenbal and national well-known intellectual B. Rinchen and Ts. Damdinsuren played an important role in success of twentieth century's Mongolians in the field of culture and education.

Ном зүй

1. Монгол Улсын Засгийн газрын архив. ф.1, т.4, хн 20
2. МАХН-ын Төв архив, ф.4, 18
3. Ю.Цэдэнбалын Академийн архив. ф.1, хн.3
4. Ю.Цэдэнбал: Хүмүүсийн дурсамж, б.1, УБ., 2002
5. Б.Ринчен. Монголын за андагаар буй заа. УБ., 2000
6. Л.Бат-Очир, Чойбалсан: Намтрын нь балархайг арилгахуй. УБ., 1996
7. Ц.Жамбалсүрэн. Ю.Цэдэнбал: Эрин зууны түүхэн элч. УБ., 2007
8. Ц.Жамбалсүрэн, Хүмүүнлэг энэрэнгүй ёс, хүний эрхийг хүндэтгэе, УБ., 2003
9. Ц.Жамбалсүрэн. МУИС: санаачлагч, үүсгэн байгуулагчид. УБ., 2005
10. Л.Шинкарев. Цэдэнбал, Филатова хоёр: Хайр дурлал, эрх мэдэл, эмгэнэл, УБ., 2004
11. Л.Батцэнгэл. Миний мэдэх Ю.Цэдэнбал, УБ., 2002
12. Есөн туг (Ю.Цэдэнбалын Академийн сонин), 2002, № 3,4
13. Хүмүүн толь (Ю.Цэдэнбалын өвийг хамгаалах сангийн сонин), 1996, №1 (14)
14. Утга зохиол, 1990. XI.30, №49
15. Манай индэр, 1990, №12

²³ Манай индэр, 1990, № 12, т. 56

²⁴ Хүмүүн толь, 1996, №1(14)